



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/а3.

Мандалговь.

Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын
газрын 2020 оны үйл ажиллагааны
үр дүнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.17 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 9.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 12.1, 13.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт -шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг нэгдүгээр хавсралтаар, Сумдын үйл ажиллагаанд анхаарах нийтлэг зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн нийтлэг хэрэгжүүлэх зөвлөмж, Хяналт -шинжилгээний үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт үр дүнг тооцон зөвлөмжийн хэрэгжилтийг 6, 11 сарын 25-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст тайлагнахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр хангалтгүй үнэлэгдсэн Дэлгэрхангай, Дэлгэрцогт сумд, дутагдалтай үнэлэгдсэн Дэрэн, Эрдэнэдалай, Хулд, Луус, Говь-Угтаал, Сайхан-Овоо сумдад тусгай удирдамж гарган байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

4. Хангалтгүй дүнтэй үнэлэгдсэн, Хяналт- шинжилгээ, үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хариуцлагагүй хандаж, хугацаатай тайлан мэдээг удаа дараа ирүүлээгүй Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ё.Сайхантуяад холбогдох хууль журамд заасны дагуу сахилгын шийтгэл хүлээлгэж, эргэн мэдээлэхийг тус сумын Засаг дарга (М.Батсүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210260

Аймгийн Засаг дарга 2021 оны 03 дугаар сарын
09-ны өдрийн А/13-тоот захирамжийн 01 дүгээр хавсралт

СУМДЫН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

№	Сумдын нэрс	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ				Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ				Дундаж		Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ		Дундаж	Ерөнхий үнэлгээ	Үнэлгээ
		Хууль тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт	Аймгийн Засаг даргын 01 тоот захирамжийн хэрэгжилт	Дундаж	Аймгийн Засаг даргас сумын Засаг даргатай байгуулсана гэрээний үүргийн биелэлт	Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиглуулах талаар байтлуулах тухайн Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт	Дундаж	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтөлтийн	Дундаж	Ерөнхий үнэлгээ			
1	БАЯНЖАРГАЛАН	78.3	81.9	89.6	83.3	87.8	93.3	87.4	84.5	88.3	75	89.8	82.4	84.6	Хэвийн	
2	ӨНДӨРШИЛ	83.6	83.7	83.2	83.5	83.8	91.6	82.3	73.8	82.9	80	90.0	85.0	83.8	Хэвийн	
3	ЦАГААНДЭЛГЭР	86.3	81.6	81.2	83.0	84.9	91.1	75.3	70.0	80.3	87.5	87.5	87.5	83.6	Хэвийн	
4	ӨЛЗИЙТ	87.5	90.6	92.0	90.0	81.7	88.2	84.4	80.4	83.7	70	80.0	75.0	82.9	Хэвийн	
5	ГУРВАНСАЙХАН	83.6	81.3	83.1	82.7	79.4	93.4	81.7	77.8	83.1	80	84.2	82.1	82.6	Хэвийн	
6	АДААЦАГ	83.3	73.5	82.0	79.6	83.6	82.5	90.9	71.0	82.0	87.5	76.4	82.0	81.2	Хэвийн	
7	САЙНЦАГААН	92.5	66.5	75.0	78.0	85.9	94.7	89.7	81.2	87.9	74	79.0	76.5	80.7	Хэвийн	
8	ХУЛД	83	58.1	70.0	70.4	77.2	62.1	65.1	66.7	67.8	82.5	83.6	83.1	73.7	Дутагдалтай	
9	ЛУУС	86.3	70.3	70.0	75.5	78.3	73.1	81.2	61.8	73.6	52	85.7	68.9	72.7	Дутагдалтай	
10	ДЭРЭН	94.5	71.9	82.9	83.1	84.7	87.3	89.1	72.0	83.3	5	92.1	48.6	71.6	Дутагдалтай	
11	ЭРДЭНЭДАЛАЙ	79.2	60.8	75.0	71.7	77.3	71	65.7	66.9	70.2	70	73.0	71.5	71.1	Дутагдалтай	
12	ГОВЬ-УГТААЛ	93.5	71.3	88.5	84.4	74.2	93.1	83.6	73.9	81.2	10	82.4	46.2	70.6	Дутагдалтай	
13	САЙХАН-ОВОО	85.3	60.6	76.3	74.1	78.6	79	69.9	61.8	72.3	60	70.2	65.1	70.5	Дутагдалтай	
14	ДЭЛГЭРЦОГТ	86.3	50.7	76.0	71.0	71.3	80.7	80.1	62.3	73.6	22.5	87.8	55.2	66.5	Хангалтгүй	
15	ДЭЛГЭРХАНГАЙ	70	64	75.2	69.7	0.0	80	66.5	51.8	49.6	60	81.6	70.8	63.4	Хангалтгүй	
	ДҮН	84.9	71.1	80.0	78.7	75.2	84.1	79.5	70.4	77.3	61.1	82.9	72.0	76.0		